

БНХАУ БОЛ МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН ГАДААД ХҮЧИН ЗҮЙЛИЙН НЭГ МӨН

*Н.Ариунгуа**

Хятад улсын эдийн засаг нь асар эрчимтэй хөгжиж байгаа орны хувьд Монгол Улсын хөгжлийн маш чухал гадаад хүчин зүйлийн нэг юм. Өнөөдөр Хятад улсын эдийн засаг маш түргэцтэй хөгжиж түүний дэлхийн эдийн засагт эзлэх байр суурь улам улмаар өсч хувийн жин нь тасралтгүй нэмэгдэж байна. Өнөөдөр Хятад улс гадаад худалдаагаар дэлхийд гуравт, гадаад валютын нөөцөөр нэгд ороод байгаа бөгөөд дэлхийн гурав дахь том зах зээл буюу Азийн хамгийн том импортын зах зээл болоод байна. Хятадын эдийн засгийн өсөлт нь олон улсын тавцан дээрхи хятадын өрсөлдөх чадварыг эрс нэмэгдүүлж, зах зээлийг шинээр нээж, улмаар шинэ өрсөлдөөн, шинэ хамтын ажиллагааны талбарыг бий болгож байна. Юуны түрүүнд Хятад улс бүс нутгийн хэмжээнд өөрийн нөлөөг бэхжүүлэх гадаад эдийн засгийн идэвхтэй бодлого хэрэгжүүлж байна. Хятад улсын эдийн засгийн түргэн өсөлт Ази болон хөрш зэргэлдээ орны эдийн засагт аюул учруулахгүй, харин ч тэдний эдийн засгийн хөгжилд асар том хөшүүрэг, дэм болно гэж хятадын тал мэдэгдэж байгаа билээ. Нөгөөтэйгүүр Хятадын үндэсний эдийн засаг хэмээх ойлголт нь БНХАУ-ын нутаг дэвсгэрээр хязгаарлагдахгүй болж, хятад хүний бизнесийн үйл ажиллагаа явуулж буй эдийн засгийн орчинг мөн хамрах хандлага гарч ирж байгаа юм. Өөрөөр хэлбэл Хятад улс эдийн засгийн үйл ажиллагаагаа гадагш нь улам тэлэх бодлогыг идэвхтэй явуулж байна. Чингэхдээ хөрш зэргэлдээ орнуудад өөрийн нөлөөгөө ихэсгэх Хятадын тууштай бодлого бол зээл санхүүгийн салбарт хөрөнгө мөнгө ихээр оруулах явдал хэмээн үзэж байгааг гадны шинжээчид тэмдэглэж байгаа. Үүний нэг тод жишээ бол Төв Азийн орнуудад Хятадын талаас олгож буй их хэмжээний зээл юм. Тухайлбал Хятад улс Туркменстанд 20 жилийн хугацаатай жилийн 3% хүүтэй 300 сая ам.долларын зээл, Узбекистанд 430 сая ам.долларын зээл тус тус олгожээ. Үүний хариуд Хятад улс Төв Азийн бүс нутгаас цахилгаан эрчим хүчний түүхий эд, хар ба өнгөт төмөрлөг, уран зэргийг импортлож байна. Сүүлийн жилүүдэд Хятадын цахилгаан эрчим хүчний хэрэгцээ улам нэмэгдэж байгаа бөгөөд газрын тос, газрын хийн

* Н.Ариунгуа - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

нөөцөө Ойрхи Дорнод, Африкийн орнуудаас хангадаг /энэ нь импортын 50%, 22% эзэлдэг/ бол сүүлийн үеэс хөрш зэргэлдээ орнуудаас энэхүү нөөцөө олж авахыг чухалчилдаг болсон ба Орос, Казахстанас эдгээр бүтээгдэхүүний нөөцөө олж авах илүү сонирхолтой болжээ. Хятад улс Төв Азиас Туркмен-Хятад хэмээх хийн хоолойгоор 30 жилийн турш жилд 30 тэрбум.куб газрын хий авах бөгөөд үүнд Казахстан, Узбекистан орнууд мөн оролцох ажээ. Ер нь хятадын эдийн засгийн боломж үйл ажиллагааны далайц их учир дэлхийн хямралыг даван туулахад Хятад маш их нөлөөтэй гэдгийг бусад орнууд хүлээн зөвшөөрч байгаа. НҮБ-ын зарим шинжээчид Хятад улсын валютын арвин сан, гадаад худалдааны үлэмж орлого, хөрөнгө оруулалт нь дэлхийн санхүүгийн хямралыг давахад тус болно гэж мэдэгдэж байна.

Дээрх нөхцөлд Монгол Улсын цаашдын хөгжлийн төлөв хүссэн хүсээгүй яах аргагүй энэ улстай холбоотойг үгүйсгэх аргагүй. Монгол-Хятадын харилцаа сүүлийн арав гаруй жил хөгжиж өнөөдөр иж бүрэн түншлэлийн түвшинд хүрээд байгаа билээ. Гэтэл одоогийн байдлаар Монгол Улс Хятадын эдийн засагт өөрийн гэсэн тодорхой байр сууриа олж аваагүй талаар манай зарим улс төрч, эдийн засагчид тэмдэглэсээр байгаа. Үнэхээр ч манай улс Хятадын бодлогыг “тоссон” идэвхгүй хэлбэрээр Хятадтай харилцаж ирснийг тэмдэглэх хэрэгтэй. Энэ нь Монгол Улс Хятадтай зах зээлийн эдийн засгийн нөхцөлд харилцаа тогтоох, ялангуяа үндэсний аюулгүй байдлын хувьд бэлтгэлгүй, өөрийн орны хөгжлийн хэтийн төлөв, хөгжлийн гадаад хүчин зүйлийн талаар ч бүрхэг ойлголттой байсантай холбоотой болов уу. Үүнийг ч Хятадын зарим эрдэмтэн судлаач нар тэмдэглэж байгаа бөгөөд хоёр орны эдийн засгийн харилцааг илүү үр өгөөжтэй хөгжүүлэхийн тулд юуны өмнө Монгол Улс өөрөө хөгжлийнхөө хэтийн төлөв, хөгжлийн загвараа сайтар боловсруулсан байх ёстой хэмээн зөвлөж байгааг дурьдас уу.¹ Үнэхээр сүүлийн жилүүдэд гадаадын хөрөнгө оруулалтыг тэнцвэртэй, нарийн тооцоотой хэрэгжүүлэх бодлого дутагдсаны улмаас манай эдийн засагт өнөөдөр олон төрлийн бэрхшээл үүсээд байгаа билээ. Тухайлбал ашигт малтмалын хууль учир дутагдалтай болсноос тавьхан мянган төгрөг төлөөд хэн дуртай нь лиценз авах боломж нээгдснээр гадаадын бизнесменүүдийн гарт маш их лиценз төвлөрсөн, байгаль орчноо сүйтгэсэн, стратегийн том ордуудаа /хар төмөрлөг, нүүрс/ хятадуудад шилжүүлснээр их хэмжээний түүхий эд Хятад руу ачигдаж байгаа зэрэг юм.

Хятад улс Монгол дахь хөрөнгө оруулалтаараа нэгд ордог нь манай хоёр орны харилцаа идэвхтэй хөгжиж байгаагийн нэг илрэл мөн. Гэвч энэхүү эдийн засгийн харилцаа нь аль хир харилцан өгөөжтэй, үр ашигтай хэрэгжиж байгаа талаар бодитойгоор хэлэхэд хүндрэлтэй. Юуны түрүүнд уул уурхайн салбар дахь Хятадын хөрөнгө оруулалттай компаниудын /том, жижиг/ олборлолт Монголын эдийн засагт хэрхэн нөлөөлж ямар хэмжээнд үр өгөөжөө өгч байгааг нарийвчлан судалсан зүйл байхгүй байна. Тухайлбал эрдэсийн бүтээгдэхүүний экспорт 2006 онд 870 сая ам.доллар болсон гэсэн тооцоо байдаг боловч үүний хэдэн хувь нь Хятад улсад ногдож тэр нь манай улсад аль хир ашиг өгснийг нарийн тооцоолон гаргасан зүйл одоогоор үгүй. Энэ бүгдээс үзэхэд Монгол Улс Хятадтай энэ салбарт харилцан ашигтай хамтын ажиллагаа хэрэгжүүлэхийн тулд хайнга байдлаасаа ангижирч, олсон ашиг орлого, алдаа дутагдлаа нарийн тооцоолон хариуцлагатай уул урхайн салбарыг хөгжүүлэх шаардлагатай болоод байна. Цаашид ч Хятад улс Монголын уул уурхайн салбарт хамтран ажиллах хөрөнгө оруулах хүсэлтэй байх бөгөөд энэ нь уул уурхайн салбар дахь түүхийн эдийн баазаа өргөжүүлэхэд чиглэгдэж буй өнөөгийн гадаад бодлогын зорилготой нь яв цав нийцэж байгаа билээ.

Нөгөөтэйгүүр Хятадын эдийн засаг эрчимтэй хөгжиж дэлхий нийтээрээ Хятадын зах зээлээс улам хамааралтай болж байгаа өнөө үед Хятад, Монгол улсын хувьд хүссэн хүсээгүй хөгжлийн чухал хүчин зүйлийн нэг яах аргагүй мөн гэдгийг дахин дурдах хэрэгтэй. Монголын эдийн засгийн бүхий л салбар, тухайлбал хүнс, хөнгөн үйлдвэр, барилга, зам тээвэр зэрэг Хятадын зах зээлээс хамааралтай байдаг. Энэхүү зах зээлийн орон зайг бусад орон тэр бүр нөхөж чадахгүй бөгөөд харин Монгол өөрөө зарим салбарын /хүнс, барилгын материал тухайлбал цемент, арматур зэргийг дотооддоо үйлдвэрлэх замаар/ энэхүү хамаарлыг багасгах боломжтой. Энэ бүгдээс үзэхэд, Хятад цаашид ч Монголын худалдааны түнш хэвээр байх бөгөөд энэ нь Хятадын зах зээлийн потенциал, зам харилцааны ойр дөт байдал, Монгол-Хятадын худалдаа эдийн засгийн харилцааны уламжлалаар тайлбарлагдана. Нөгөөтэйгүүр манай хойт хөрш Орос улс гэвэл дээрхи салбарт Монголын зах зээл дээр Хятадтай өрсөлдөх боломжоор одоогоор хомс бөгөөд харин тодорхой чиглэл, салбарт өөрийн нөлөөгөө өргөтгөхийг хичээж байгаа.

Монгол-Хятадын худалдаа өөрийн гэсэн онцлогтой бөгөөд Монгол нь Хятадаас бараагаа Хятадын хилийн боомт Эрээнээс гол төлөв татдагаас үзвэл манай хоёр орны худалдааны үйл ажиллагаа нь зарим талаараа орон нутгийн шинж чанартай өнөөг хүртэл хөгжиж ирсэн гэж хэлж болохуйц. Энэ нь манай улсын хувьд маш чамлалттай үзүүлэлт юм. Нөгөө нэг онцлог нь манай хоёр орны хоорондын худалдаа нь тэнцвэргүй явагдаж байгаа явдал юм. Өөрөөр хэлбэл Хятад улс руу манай гаргаж буй зүйл бол гол төлөв уул уурхайн салбарын түүхий эд байдаг бол харин Хятадаас оруулж ирж буй бараа таваар нь өдөр тутмын хэрэгцээг хангах зүйл болох хувцас хунар, гурил, будаа, хүнсний ногоо, жимс жимсгэнэ хийгээд барилгын төрөл бүрийн материал гэх мэт. Энэ нь зөвхөн манай хоёр орны хоорондын худалдааны онцлог биш бөгөөд Хятад бусад хил залгаа орнуудтай хийж буй худалдаа ч ийм шинж бүхий байдаг гэж үзэж болох. Гэвч манай улс Хятадтай хийж буй худалдааны эргэлтээ бодитойгоор гаргаж чадахгүй байгаа нь маш учир дутагдалтай. Тухайлбал Монгол-Хятадын худалдааны нийт эргэлт 2007 онд 811 сая ам.доллар гэсэн албан ёсны тооцоо байдаг. Гэтэл энэ нь хувь хүмүүсийн гар тээшээр оруулж ирж буй барааны дүнг тусгаагүй бөгөөд хэрэг дээрээ Монгол-Хятадын худалдааны эргэлт дээр дурьдсан үзүүлэлтээс хамаагүй их байгаа. Иймээс манай тал Монгол-Хятадын худалдааны жинхэнэ эргэлтийн хэмжээг бодитойгоор гаргах нөхцөлд Хятадын зах зээлээс ямар хэмжээнд хамааралтай, валютын урсгалын хэмжээ хир байгаагаа сая нарийн тодорхойлох боломжтой юм. Учир нь шинжээчдийн анхааруулж байгаагаар худалдааны тэнцвэргүй байдал удаан хугацаагаар үргэлжлэх хийгээд капиталын хөдөлгөөн улам нэмэгдэх тохиолдолд валютын курст савалгаа үүсч үндэсний эдийн засгийн бүтцийг өөрчлөх хүртэлх хэмжээнд нөлөөлж болзошгүй. Хятадтай хил залгаа бусад орнууд энэхүү байдлаас гарах арга замыг хайж байна. Тухайлбал Оросын Алс Дорнод нээлттэй бүс /портовые зоны/ байгуулж түүхий эдийг тус бүсэд хагас болон бүтэн боловсруулах боломжийг хайж байгаа жишээг дурдаж болно.²

Монгол-Хятадын эдийн засгийн харилцааны нэг анхаарал татсан асуудал бол Хятадын хөрөнгө оруулалт юм. Гадаадын хөрөнгө оруулалт бол эдийн засгийн хөгжилд асар том хөшүүрэг болох салбар хийгээд чухамхүү гадаад эдийн засгийн энэхүү үйл ажиллагаа нь дотоод хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байх ёстой. Иймээс бид цаашид Хятадын хөрөнгө

оруулалтын асуудалд илүү няхуур хандаж, аар саар жижиг хөрөнгө оруулалтаас аль болохоор татгалзаж чухамхүү Монголын эдийн засгийн хөгжилд үр өгөөжөө өгөх хөрөнгө оруулалтыг дэмжих шаардлагатай байна. Энэ нь нөгөө талаас Монголын зах зээл дээрх хятадын хөдөлмөрийн хүчний хэмжээг хянах замаар зохих хэмжээнд нь барьж байх бололцоог бий болгох юм. Чингэхдээ хөрөнгө оруулалтын үр дүнг ил тод мэдээлж байх нь хоёр орны хамтын ажиллагааг олон нийтэд ойлгуулахад чухал ач холбогдолтой. Энд тэмдэглэхэд, Хятад Улс өөрийн зүгээс Монгол дахь Хятадын нэр хүнд ард иргэдийн дунд сүүлийн үед унасан болон бусад улс гүрнүүдийн ашиг сонирхол Монголд өсч байгаатай /Монголын эрдэс баялгийг сонирхох болсон зэрэг/ холбоотой Монголын талаар явуулж буй бодлогоо илүү оновчтой болгох, зарим нэгэн алдаа, дутагдлыг засч залруулах шаардлагатай гэж үзэж байгаа бололтой. Энэхүү шаардлага нь Хятадын “шинэ дипломат бодлого” хэрэгжиж байгаатай ч холбоотой.

Монгол-Хятадын эдийн засгийн харилцааны төлөв байдлыг ерөнхийлөн базаж хэлэхэд, Монголын хувьд Хятад улс газар нутгийн хувьд хамгийн ойр, ашигтай зах зээл бөгөөд Хятадын хувьд Монгол нь Хятадын бараа таваарыг борлуулах бүс нутгийн хэмжээн дэх зах зээл мөнөөс гадна Хятадын хэрэгцээг хангахуйц байгалийн нөөцөөр баян улс юм. Иймээс ч Монгол нь зээлдэгч орны хувьд мөн эрсдэл багатай улс хэмээн тооцогдоно. Нөгөөтэйгүүр хил дамнасан олон улсын эдийн засгийн төсөлд хамрагдах боломжийг Хятад улс бий болгож байгаагаараа Монгол Улсын хувьд бас ашигтай. Тухайлбал 2007 оны 9-р сард БНХАУ-ын Төрийн Зөвлөлөөс манай оронтой хил залгаа СУӨЗО-ны талаар гаргасан “СУӨЗО-ны эдийн засаг-нийгмийн хөгжлийг түргэсгэх талаархи зарим арга хэмжээ” хэмээх баримт бичигт СУӨЗО нь Төв Азийн орнуудтай хил залгаа учир түүнийг олон улсын зах зээл рүү гарах гарц, олон улсын худалдааны төв болгох зорилттой байгааг заагаад “Евразийн тив хоорондын шинэ коридор”-ыг бий болгож эх газрын Хятадыг төв, өмнөд, баруун Ази болон Европын улс гүрнүүдтэй холбох тухай дурджээ. Хэрэв энэхүү төлөвлөгөө хэрэгжих нөхцөлд манай улсад ч асар их бололцоо бий болох нь мэдээж юм. Гэвч манай улс эдийн засгийн хувьд хүчирхэг хөрш оронтойгоо илүү нээлттэй харилцахад тэр бүр бэлэн бус байгаа бололтой. Үүнийг Замын-Үүдэд нээлттэй бүс байгуулах төсөл өдгөө хүртэл ахиц муутай явагдаж байгаагаас харж болох юм.

Ийнхүү Монгол Улсын хөгжил, шинэчлэлийн үйл явц хөрш Хятад улсын хамтын ажиллагаагүй өрнөх ямар ч бололцоогүй юм. Хятад улс ч манай улстай худалдаа, хөрөнгө оруулалт, банк санхүү зэрэг эдийн засгийн хамтын ажиллагааны янз бүрийн хэлбэрийг хэрэгжүүлэх сонирхолтой байгаа билээ. Иймээс чухамхүү эдийн засгийн хамтын ажиллагаагаа хөгжүүлэх хоёр талын сонирхол нь хоёр орны түншлэлийн чухал үндэс болох ёстой. Нөгөөтэйгүүр Монгол Улс БНХАУ-тай харилцах харилцааг гадаад бодлогынхоо тэргүүлэх чиглэл хэмээн тодорхойлсныхоо дагуу мөн тус улстай харилцах тэргүүн зэргийн бодлого боловсруулах шаардлагатай байна.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. “Good neighborli relations of Mongolia and PRC and future perspectives” эрдэм шинжилгээний бага хурал. Улаанбаатар 2008, 10 сар
2. А.Санжиев. Портовые зоны на Дальнем Востоке России: прошлое и будущее –ПДВ 2008, №5, стр.58.